

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Боловсролын ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/3 дугаар зүйлийн 3.1.25-3.1.29 дахь заалт:**

“3.1.25. “багш” гэж багшийн мэргэжил эзэмшсэн, эсвэл багшлах эрхийн гэрчилгээтэй, манлайлал, хариуцлага, ёс зүйтэй багшлах мэргэжилтэн, сурган хүмүүжүүлэгчийг;

3.1.26. “багшийн туслах” гэж хүүхэд бүрийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн асран хамгаалах, хөгжүүлж хүмүүжүүлэхэд чиглэсэн багшийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах ажилтныг;

3.1.27. “боловсролын удирдах ажилтан” гэж цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн захирал, сургалтын менежер, арга зүйчийг;

3.1.28. “боловсролын мэргэжлийн ажилтан” гэж цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, номын санч, хоол зүйч, эмчийг;

3.1.29. “боловсролын нийтлэг үйлчилгээний ажилтан” гэж цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн нягтлан бодогч, нярав, архив, бичиг хэргийн ажилтан, тогооч, туслах ажилтан, үйлчлэгч, сантехникч, цахилгаанчин, галч, жижүүр, манаачийг;

#### **2/13 дугаар зүйлийн 13.3.7-13.3.11 дэх заалт:**

“13.3.7. Засгийн газраас төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн багш, удирдах болон мэргэжлийн ажилтны үндсэн цалинг улсын дундаж цалингаас багагүй хэмжээтэй байхаар тооцож, инфляцийн түвшинтэй уялдуулан жил бүр шинэчлэн тогтоох;

13.3.8. Хувийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага нь багш, удирдах болон мэргэжлийн ажилтны үндсэн цалинг харгалзах түвшний төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах болон мэргэжлийн ажилтны үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлстэй тэнцүү байхаар тогтоох;

13.3.9. төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн боловсролын нийтлэг үйлчилгээний ажилтны үндсэн цалин болон багшийн үндсэн цалингийн зөрүү хорин хувиас илүүгүй байх;

13.3.10. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг бүлэгт хичээллэх суралцагчийн тоо боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс тогтоосон нормативаас хэтэрсэн тохиолдолд хүүхдийн тоотой уялдуулсан цалингийн нэмэгдэл олгох;

13.3.11. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн анги, бүлэг удирдсан багшийн нэмэгдлийг тухайн анги, бүлгийн суралцагчийн тоотой уялдуулан олгох.”

**3/24 дүгээр зүйлийн 24.1.15 дэх заалт:**

“24.1.15. энэ хуулийн 13.4-т заасан хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх журмыг батлах;”

**4/28 дугаар зүйлийн 28.4.3 дахь заалт:**

“28.4.3. аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг таван жилийн хугацаатай томилох бөгөөд ажлын үр дүн, гүйцэтгэлд үндэслэн, удирдах ажилтны манлайлал, хариуцлага, ёс зүйтэй байдлыг харгалзан нэг удаа гурван жилийн хугацаагаар улируулан томилох.”

**5/28 дугаар зүйлийн 28.5.3 дахь заалт:**

“28.5.3. дүүргийн боловсролын хэлтсийн даргыг таван жилийн хугацаатай томилох бөгөөд ажлын үр дүн, гүйцэтгэлд үндэслэн, удирдах ажилтны манлайлал, хариуцлага, ёс зүйтэй байдлыг харгалзан нэг удаа гурван жилийн хугацаагаар улируулан томилох.”

**6/33 дугаар зүйлийн 33.2.3 дахь заалт:**

“33.2.3. төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль болон насан туршийн суралцахуйн төвийн захирлыг таван жилийн хугацаатай томилох бөгөөд ажлын үр дүн, гүйцэтгэлд үндэслэн, удирдах ажилтны манлайлал, хариуцлага, ёс зүйтэй байдлыг харгалзан нэг удаа гурван жилийн хугацаагаар улируулан томилох.”

**7/37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг:**

“37.1.Тухайн жилийн төсвийн тухай хуулиар тооцоолсон дотоодын нийт бүтээгдэхүүний долоогоос доошгүй хувийг, эсвэл улсын төсвийн нийт зардлын хориос доошгүй хувийг боловсролын салбарт зарцуулахаар төлөвлөж хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Боловсролын ерөнхий хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг:**

“4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, мэдлэг чадвартай, ёс суртахуунтай, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино.”

#### **2/12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсэг:**

“12.7.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид дараах дэмжлэгийг төрөөс үзүүлнэ:

“12.7.1.сургалтын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт олгох;

12.7.2.сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээтэй амжиргааны тэтгэлэг олгох;

12.7.3.багш мэргэжлээр амжилттай суралцаж, амжиргааны тэтгэлэг авсан хугацааг багшаар ажилласанд тооцох;”

#### **3/13 дугаар зүйлийн 13.3.1 - 13.3.4 дэх заалт:**

“13.3.1. хөдөлмөрийн онцлогийг харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн захирал, эрхлэгч нарт ажлын 21 өдөр, бусад ажилтанд ажлын 27 өдөр, багш, багшийн туслах, дотуур байрны багш, нийгмийн ажилтан, хоол зүйч, сэтгэл зүйч, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт олгох;

13.3.2. тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан багш, боловсролын удирдах болон мэргэжлийн ажилтан, боловсролын нийтлэг үйлчилгээний ажилтнууд нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг авах;

13.3.3. сум, баг, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгон дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн багш, мэргэжлийн болон удирдах ажилтанд гурван жил тутамд, боловсролын нийтлэг үйлчилгээний ажилтанд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох;

13.3.4. төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвд 25-аас дээш жил ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн багш, боловсролын мэргэжлийн болон удирдах ажилтан өөрөө хүсвэл эмэгтэй 50, эрэгтэй 55 настай тэтгэвэрт гарч болох бөгөөд тэдгээрт ажилласан нэг жилийг нь нэг аравны таван /1,5/ жилээр тооцон Төрийн албаны тухай хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;”

#### **4/13 дугаар зүйлийн 13.3.6 дахь заалт:**

“13.3.6. төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвд 15-аас доошгүй жил ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах;”

#### **5/13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсэг:**

“13.8. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, буцалтгүй тусламж авсан багш, ажилтныг төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд үргэлжлүүлэн ажиллуулсан бол

түүний ажлын нормыг тохируулах, цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшуулал, тэтгэмжийг хэрхэн олгох журмыг Засгийн газар батална.”

#### **6/24 дүгээр зүйлийн 24.1.6, 24.1.7 дахь заалт:**

“24.1.6. төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын хувьсах зардлын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас дөрөв дахин үржүүлсэнтэй тэнцүү байхаар тооцон инфляцийн түвшинтэй уялдуулан жил тутам шинэчлэн тогтоох;

24.1.7. төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардлын хувь, хэмжээг инфляцийн түвшинтэй тэнцүү хувиар жил бүр шинэчлэн тогтоох;”

#### **7/33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг:**

“33.2.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль болон насан туршийн суралцахуйн төвийн захирал дараах тусгай шаардлагыг хангасан байна:

33.2.1.багш, сургуулийн нийгмийн ажилтан мэргэжлээр их, дээд сургууль төгссөн боловсролын удирдлага, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний чиглэлээр энэ хуулийн 27.1.2-т заасан мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, төгссөн байх;

33.2.2.боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагад багшаар зургаагаас доошгүй жил, заах аргын нэгдлийн болон мэргэжлийн хөгжлийн бүлгийн ахлагч, сургалтын менежер, арга зүйч, **захирал**, эрхлэгчээр дөрвөөс доошгүй жил, эсвэл сургуулийн нийгмийн ажилтнаар 10-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй байх.”

**3 дугаар зүйл.**Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн гарчгийн “” гэснийг “Багш, боловсролын мэргэжлийн болон удирдах ажилтныг бэлтгэх, тэдний мэргэжлийн хөгжлийн тогтолцоо” гэж, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг “Багшаас бусад мэргэжилтэй иргэн багш бэлтгэх нэгээс доошгүй жилийн хугацаатай хувилбарт сургалтад хамрагдан багшаар ажиллаж болно.” гэж, 13 дугаар зүйлийн гарчгийн “Багшийн эрх, үүрэг, багш, ажилтны нийгмийн баталгаа” гэснийг “Багшийн эрх, үүрэг, багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгаа” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалтын дугаарыг “24.1.16” гэж, 37 дугаар зүйлийн 37.1-37.6 дахь хэсгийн дугаарыг “37.2-37.7” гэж, 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийн “37.1, 37.4-т” гэснийг “37.2, 37.5-т” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.13 дахь заалтыг хассугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ....-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг